



ХОТ, СУУРИНЫ УС  
ХАНГАМЖ, АРИУТГАХ  
ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ  
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2019



БОХИР УСЫГ ЦЭВЭРЛЭХ,  
ДАХИН АШИГЛАХ



АЮУЛГҮЙ БАТАЛГААТ  
УНДНЫ УС



ЭРҮҮЛ АХУЙН  
ШААРДЛАГА ХАНГАСАН  
АРИУН ЦЭВРИЙН  
БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ

## МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт нийтийн аж ахуйн салбарын нийт ажилтан, албан хаагч, мэргэжил нэгт нөхөд Та бүхэндээ сайхан ирээдүй, сайн үйлсийг бүтээх эрхэм хүсэл бүхэн тань ирж буй шинэ онд биелэн бүтэхийн өлзийтэй ерөөлийг Та бүхэндээ хамтатган өргөн барья.

2019 онд Зохицуулах зөвлөлийн хамт олон бид хуулиар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд нийтийн аж ахуйн салбарын хууль эрх зүйн орчинг бэхжүүлсэн, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зохицуулалтыг сайжруулсан, хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх, ашгийг тэнцвэртэйгээр хамгаалсан, салбарын

болон Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулсан он болж Зохицуулах зөвлөлийн түүхэнд бичигдэн үлдлээ.

Тогтвортой Хөгжлийн Үзэл баримтлалын хүрээнд баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэхэд дан ганц төр засгийн оролцоо, дэмжлэг төдийгүй Та бидний болон иргэн бүрийн хамтын нэгдсэн чармайлт нэн тэргүүнд тавигдаж байж ус хангамж, ариутгах татуургын асуудлаар **Хэнийг ч ардаа орхихгүй** байх нөхцөл бүрдэнэ.

Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, хамтран ажиллаж буй Та бүхэндээ гүн талархал илэрхийлье.

Цаашид бид усны хангамж, ариутгах татуургын салбарын үйлчилгээний үр шимийг дээшлүүлж, найдвартай үйлчилгээ, шинэ боломж, сонголтуудыг бий болгон ард иргэдийнхээ тав тухтай ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.БАТСУУРЬ

## ОРШИЛ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар Зохицуулах Зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуурга /цаашид “УХАТ” гэх/-ын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй бөгөөд хуулийн 10 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Зохицуулах Зөвлөл Монгол Улсад УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэн, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хот, суурины хэрэглэгчдэд хүргэх, баталгаажуулах оновчтой зохицуулалтыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

## НЭГ. Хуулийн хэрэгжилт





## Үнэ, тарифын чиглэлээр



### ***1.1. Хуулийн 10.1.1 дэх заалт буюу цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх ажлын хүрээнд:***

Улаанбаатар хотын цэвэр, бохир усны тарифыг 2019 оны 23 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоосонтой холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч 83 аж ахуйн нэгж, байгууллагын зардалд хяналт хийж бөөний тариф тогтоосон бөгөөд 20 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ-ийн ирүүлсэн материалыг хянаж борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг шинэчлэн мөрдүүлсэн.

Дээрх зохицуулалтаас гадна 2019 онд 16 тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын саналыг хянаж, бөөний тариф, борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг шинэчлэн батлууллаа. Мөн 13 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн "ОСНААУГ" ОНӨААТҮГ-тай тооцоо хийх дамжин тарифыг баталсан.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн хэм хэмжээний 13 актыг хэрэглэгчийн нөлөөллийн шинжилгээ, тайлбар, судалгааны хамт материал бүрдүүлж, файлын сан үүсгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэв.






График 2. УХАТ-ын үзүүлэлт, 2014-2019 он



**1.2. Хуулийн 10.1.2 дахь заалт буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээг тогтоох ажлын хүрээнд:**

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгуулагаас авах үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын тайлан, тарифт тусгасан хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө зэргийг авах маягтыг шинэчлэн боловсруулсан.



## Тусгай зөвшөөрлийн чиглэлээр



### ***1.3. Хуулийн 10.1.3 дахь заалт буюу тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажлын хүрээнд:***

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нийт 90 материалыг тухай бүр хүлээн авч хянан, үүнээс нөхцөл, шаардлага хангасан 68 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах, хүчингүй болгох болон тодорхой хугацаагаар үүрэг даалгавартайгаар хойшлуулах асуудлыг Зохицуулах зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж, шийдвэрлэв.


Тайлант хугацаанд 21 аж ахуйн нэгж, байгууллагад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 42 аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг сунгаж, 5 аж ахуйн нэгж байгууллагын зөвшөөрлийг хүчингүй болгож, 2 аж ахуйн нэгж, байгууллагад үүрэг даалгавар өгч, тодорхой хугацаагаар хойшлуулсан. Тусгай зөвшөөрөл сунгуулсан болон шинээр авсан тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй гүйцэтгэлийн гэрээг шинэчлэн байгууллаа. /Хүснэгт 1/

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл шийдвэрлэсэн байдал

№	Тусгай зөвшөөрлийн нэр, төрөл	Шинээр олгосон	Сунгасан	Хүчингүй болгосон
1	Орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам, сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр	4	29	5
2	Аймаг, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр	-	9	
3	Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр	11	2	
4	Цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, байгуулах болон УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ	4	-	
5	Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ болон туршилт, тохируулгын байгууллага	2		
6	Ус олборлон, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ		2	
<b>Нийт</b>		<b>21</b>	<b>42</b>	<b>5</b>

Хүснэгт 1-ээс харахад шинээр олгосон 21, сунгуулсан 42, хүчингүй болсон 5, нийт 68 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

График 1. Тусгай зөвшөөрлийн асуудал шийдвэрлэлтийн байдал





2019 оны байдлаар улсын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг харуулбал:

Хүснэгт 2

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төрөл	Тоо
1	Орон нутгийн НААҮ-ний байгууллагууд	50
2	Улаанбаатар хотын орон сууцны УХАТ-ын байгууллагууд	3
3	Улаанбаатар хотын хувийн хэвшлийн орон сууцны УХАТ-ын тусгай зөвшөөрөл эзэмшигч	82
4	УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээний байгууллагууд	3
5	Цэвэрлэх байгууламж шинээр барих болон туршилт тохируулгын үйлчилгээний байгууллагууд	4
6	Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ болон туршилт тохируулгын үйлчилгээний байгууллагууд	2
7	Цэвэр ус цэвэршүүлэн савлах үйлдвэр	4
8	Бохир усыг тусгай зориулалтын машинаар соруулах үйлчилгээний байгууллагууд	54
<b>Нийт</b>		<b>200</b>

График 2. ТЗЭ аж ахуйн нэгж байгууллагуудын тоо



Түүнчлэн давхардсан тоогоор нийт 60 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээний хавсралтад өөрчлөлт хийж орон сууцны бүртгэлийг Зохицуулах зөвлөлийн мэдээллийн санд бүртгэв.



**1.4. Хуулийн 10.1.4 заалт буюу тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах:**

Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах хүсэлт гаргасан 71 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг газар дээр нь очиж шалган, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын дагуу дүгнэлт гарган ажиллав. Тухайлбал, Улаанбаатар хот, Сэлэнгэ, Баянхонгор, Ховд, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Орхон, Өвөрхангай зэрэг аймаг, орон нутгийн нийт 48 байгууллагын үндсэн үйл ажиллагаатай танилцан, тухайн нутаг дэвсгэрт ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний хүртээмж, чанарт дүн шинжилгээ хийж, цаашид анхаарч ажиллах шаардлагатай зүйлсийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Зохицуулах зөвлөлөөс 2019 оны хяналт, шалгалтын ажлыг графикайн дагуу хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу Нийслэлийн нутаг дэвсгэрт ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээ эрхэлж буй тусгай зөвшөөрөл бүхий давхардсан тоогоор хувийн хэвшлийн 86 аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.



Дээрх хяналт шалгалтаар аж ахуйн нэгж, байгууллагуудад илэрсэн нийтлэг зөрчил дутагдлыг дурдвал:

- НАА-н байгууллагуудад мэргэжлийн инженер техникийн ажилчид дутмаг;
- Тоног төхөөрөмжийн хаягжилт, ашиглалтын журнал, аюулгүй ажиллагааны дэвтэр тогтмол хөтөлдөггүй;
- Диспетчерийн ажлын байрны нөхцөл Орон сууцны барилгын үйлчилгээ MNS5681:2006 стандартын шаардлагыг хангаагүй;
- Ороннутгийн НАА-н байгууллагуудад усны шинжилгээний тоног төхөөрөмжийн хангалт муу, шинжилгээ хийх ажлын байр байхгүй;
- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого чиглэл тодорхойгүй, санхүүгийн бүртгэл тооцоо дутмаг зэрэг болно.



**1.5. Хуулийн 10.1.5 заалт буюу тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ажлын хүрээнд:**

2019 онд иргэн, аж ахуйн нэгжээс нийт 32 өргөдөл гомдол, асуудал шийдвэрлүүлэх албан бичиг 43 ирсэн бөгөөд өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэв /хэрэгжилт 100 хувь/.

Хангагч, хэрэглэгчийн хооронд үүссэн үнэ тарифтай холбоотой 15, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд үүссэн үнэ тарифтай холбоотой 5 маргаантай асуудлыг шийдвэрлэв.

**1.6. Тусгай зөвшөөрлийн журам, аргачлал, зааврыг боловсронгуй болгох, хууль, дүрэмд санал өгөх чиглэлээр:**

- Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/909 дүгээр захирамжаар батлагдсан “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах дэд хөтөлбөр”-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тайлан мэдээ, танилцуулгыг боловсруулан гаргав.



- “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө” түүний хэрэгжилтийн талаар тайлан мэдээг гаргаж, танилцуулга бэлдэв.



- ЭМЯ-аас зохион байгуулж буй Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Дорнод, Завхан, Орхон аймгуудад ажиллан, усны аюулгүй байдлын талаарх дүгнэлтийг гаргав.
- “Улаанбаатар хотын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын орон сууцны барилга, байгууламж, хамрах хүрээг бүртгэх журам”-ыг шинэчлэн, боловсруулж, Зохицуулах зөвлөлийн даргын 2019 оны А/49 тоот тушаалаар батлав.
- БХБЯ-наас “Бохир ус цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, гарц, шийдэл” сэдэвт хэлэлцүүлэг 2019.05.08-ны өдөр БХТ дээр зохион байгуулагдахад оролцлоо.





- БОАЖЯ-ны Азийн сангийн хэрэгжүүлж буй «Хүлэмжийн хийг бууруулах» төслийн хэлэлцүүлэгт оролцож санал өгөв.
- “ТА9100-МОН” төвлөрсөн бус цэвэрлэх байгууламж, бие даасан ариун цэврийн байгууламжаас гарах лагийг дахин ашиглах, менежментийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд лагийн дахин ашиглалт, менежментийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зөвлөлдөх уулзалтад оролцож санал, зөвлөмжийг өгөв.



Зохицуулах зөвлөлөөс Тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн төрлийн нэр, томъёог шинэлэн боловсруулж, Үндэсний Статистикийн хорооны даргын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/175 тоот тушаалаар батлуулав.

- Азийн хөгжлийн банкинд “Дархан ус суваг” ХК-ийн “гэр хорооллын хэрэглэгчдийн ус түгээх байруудыг ухаалаг болгох” санал боловсруулж хүргүүлэв.



## **ХОЁР. Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын төсөл боловсруулах**


- 2.1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулан, холбогдох баримт бичиг, судалгааны материалыг бэлтгэж хууль санаачлагчид өргөн барьсны дагуу Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгийн хорооны хурлаар орж, УИХ-ын 2019.12.12-ны өдрийн Чуулганы нэгдсэн хуралдаанаар орж анхны хэлэлцүүлгээр батлав. Хуульд нэмэлт орсноор тус Зохицуулах зөвлөл нь улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл бүрдэв.



- 2.2. БХБЯ-наас боловсруулсан Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын талаар баримтлах бодлогын баримт бичгийн болон “150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөрийн төслүүдэд холбогдох санал боловсруулж, хүргүүлэв.



- 2.3. Зохицуулах зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан БХБЯ-аар уламжлуулан, яамдын саналыг авч Засгийн газрын 2019.05.29-ний өдрийн 212 дугаар тогтоолоор батлуулав.



- 2.4. Зохицуулах зөвлөлөөс 2019.11.11-ний өдрийн 01/944 тоот албан бичгээр НААҮ-ний байгууллагуудын тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр Нийтийн аж ахуйн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох баримт

материалын хамт боловсруулан БХБЯ-аар уламжлуулан, яамдын саналыг авч Засгийн газрын 2019.12.26-ны өдрийн хуралдаанаар батлав.

- 2.5 Зохицуулах зөвлөлөөс аймаг, орон нутгийн усны аюулгүй байдлыг хангуулах, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн харуул хамгаалалтыг сайжруулах талаар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн харуул хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалалт”-д өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

## ГУРАВ. Зохицуулах зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах

- 3.1. Зохицуулах зөвлөлийн 2019 оны 1-12 дугаар сарын хуралдааныг батлагдсан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь зохион байгуулав. Хуралдаанаас нийт 114 тогтоолыг батлан гаргасан бөгөөд тогтоолыг холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагад өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.



- 3.2. Зохицуулах зөвлөл нь 2019 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 980 албан бичиг хүлээн авч бүртгэл хөтлөн, хариуцсан мэргэжилтэнүүд нь судлан шийдвэрлэн, ажиллаж байна. Үүнээс хаагдсан 972, шийдвэрлэх шатандаа 8 /гүйцэтгэл 99%/ албан бичиг байна. Мөн нийтдээ 1050 албан бичгийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад явуулав.

- 3.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай нийт 30 гэрээг байгуулан ажиллав.





- 3.4. 2019 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийтдээ 57 өргөдөл, гомдол /боловсон хүчинтэй холбоотой 10, иргэд, хуулийн этгээдээс 47/ ирснээс 56 нь хариу өгч шийдвэрлэсэн /биелэлт 98%/ байна.
- 3.5. Ажлын албадаас томилолтын журмын дагуу гадаад улсад 10, орон нутагт 8 удаа, хотод 41 удаа тус тус томилолтоор ажиллаж, холбогдох тайланг гаргуулав.
- 3.6. Давж заалдах шатны шүүхэд хянагдаж байсан “Зүмбэр орд өргөө” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хариу тайлбар, хүсэлт гаргах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах нотлох баримтыг гаргах, хяналтын шатны шүүх хуралдаанд оролцов. Захиргааны хэргийн Хяналтын шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлэв.
- 3.7. Зохицуулах зөвлөлийн даргын нийт 64 тушаал /үйл ажиллагаатай холбоотой 54, боловсон хүчний 12/-ыг баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллав.

## **ДӨРӨВ. Зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх**

- 4.1. Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны талаар өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр олон нийтэд мэдээлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулав. Үүнд:
  - 4.1.1. Дэлхийн усны өдрөөр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан усны боловсрол олгох хичээлийн талаарх мэдээллийг Өнөөдөр сонины 2019.03.22-ны дугаарт, Зохицуулах зөвлөл болон Шинжлэх Ухааны Академийн хамтын ажиллагааны талаарх мэдээллийг Өдрийн сонины №074(6175) дугаарт тус тус нийтлүүлэв.
  - 4.1.2. Зөвлөлийн дарга Ж.Батсуурь дараах олон нийтийн телевизүүдэд мэдээ, ярилцлага өгсөн. Үүнд:
    - ТВ9 телевизид 2019.03.04-нд усны үйлчилгээний талаар
    - 05 сарын 01-нд МҮОНРТ-д “Салбарт тулгамдаж буй асуудал” сэдвээр, 06 сарын 17-нд Өглөө хөтөлбөрт орон нутаг дахь цэвэр, бохир усны үйлчилгээний талаар



- НҮБ-ийн Хүүхдийн сангийн бүсийн зөвлөх Эваристе Коуасси-тэй хамт 2019.09.23-нд Bloomberg телевизийн “Зочны цаг”-аар Монголын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нөхцөл байдал, цаашид сайжруулах шинэ инновацийг хэрхэн нутагшуулах талаар
- 10 сарын 23-нд МҮОНРТ-ийн “Зочны цаг”, Eagle телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгт оролцож ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн өнөөгийн байдал, үйлчилгээний чанар, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай, Монголын радиод Усны чанар, аюулгүй байдлын талаар
- 10 сарын 29-нд ESO телевизийн “Эрүүл Монгол” нэвтрүүлэгт оролцож усны чанар, аюулгүй байдлын талаар

4.1.3. Зохицуулах зөвлөлөөс 4 сарын 17, 24-ны өдрүүдэд МҮОНТВ, ETV, Малчин ТВ, Зориг ТВ, Үндэсний радио, ФМ104,5-д тус тус усны үйлчилгээний үнэ тарифын зохицуулалтын талаар мэдээлэл хийв.



4.1.4. Зохицуулах зөвлөл, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Шинжлэх Ухааны академи, Монголын Мянганы сорилтын сангийн төлөөлөгчид 2019.05.23-ны өдрийн МҮОНРТ-ийн Монголын мэдээ сувгийн Парламентын хэлэлцүүлэгт оролцож “Хүн амын ус хангамжийн бодлого, хууль эрх зүйн орчин” сэдвээр ярилцав.




4.1.5. Дэлхийн Усны холбооноос Австрали улсын Брисбани хотод зохион байгуулсан “Цэвэрлэх байгууламжийн дэвшилтэд технологи 2019” эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл, “Сингапурын усны түүх” номуудыг тус тус орчуулж, хэвлүүлэв.



- 4.1.6. Зохицуулах зөвлөлөөс 2019 оны 10-р сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулсан “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт Үндэсний зөвлөлдөх уулзалтын талаарх мэдээллийг 8 телевиз, 10 сайт, 3 сонинд тус тус өгөв.
- 4.1.7. Өдрийн сонины №222(6323) дугаарт Нийслэлийн Байгаль орчны газрын захиалгаар ШУА-тай хамтран Хан-Уул дүүргийн хүн амын ундны усны чанарт хийж байгаа шинжилгээ судалгааны талаар мэдээлэл гаргав.
- 4.1.8. “Дэлхийн 00-ын өдөр”-ийг тохиолдуулан 11 сарын 14-нд МҮОНРТ-ийн Монголын мэдээ сувгийн Парламентын хэлэлцүүлэгт оролцож Ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдал, хөрсний бохирдол ярилцлага өгөв.



- 4.1.9. Олон нийтэд зориулсан “Цэвэр, бохир усны үйлчилгээ танай гэрт” богино хэмжээний анимейшнийг бэлтгэн гаргав.







- 4.2. Байгууллагын цахим хуудсанд 2019 оны байдлаар нийт 107 удаа, байгууллагын фейсбүүк хуудсанд нийт 206 удаа мэдээ, мэдээлэл бэлтгэн, шинэчилж байршуулав.
- 4.3. “Дэлхийн 00-н өдөр”-өөр Баянзүрх дүүргийн Өрхийн эмнэлгүүдийн хэмжээнд зохиогдсон “Ариун цэврийн байгууламж”-ийн талаарх хэлэлцүүлэгт илтгэл тавьж, эмч нарт мэдээ мэдээллээр хангав.
- 4.4. БХБЯ-наас 2019.06.20-ны өдөр цаг үеийн асуудлаар хэвлэлийн бага хурал хийсэн бөгөөд Зохицуулах зөвлөлийн зүгээс баримталж буй салбарын бодлого, үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй томоохон төсөл, арга хэмжээнүүдийн талаар танилцуулж, хэвлэл, мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэв.
- 4.5. Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласны дагуу Засгийн газрын үйл ажиллагааг сурталчлан таниулах Барилга, хот байгуулалтын салбарын нээлттэй өдөрлөгийг 2019.09.23-ны өдөр зохион байгуулав. Өдөрлөгөөр салбарын хөрөнгө оруулалт, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, томоохон арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлаа тайлагнаж, иргэдэд төрийн зарим үйлчилгээг газар дээрээс нь хүргэн, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа.



- 4.6. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын 88 жилийн ойг угтан Зохицуулах зөвлөлөөс Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай хамтран “Хэрэглэгчдээ сонсьё” нээлттэй өдрийг 2019.10.11-ний өдөр орон даяар 6 дахь жилдээ нэгдсэн журмаар зохион байгуулав.



## ТАВ. Хамтын ажиллагаа

### Дотоод хамтын ажиллагааны чиглэлээр

5.1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөрийн холбогдох зорилтуудыг хангуулах, төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулах, түүний хэрэгжилтийг хангах, олон нийтэд сурталчилан таниулах чиглэлээр Барилга, хот байгуулалтын яамтай хамтран ажиллах санамж бичгийг 2019.02.01-ний өдөр байгуулав.



5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын цэвэр, бохир усны хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулга болон ашиглалт, засвар үйлчилгээнд хяналт тавих, холбогдох сургалтыг зохион байгуулах, хэмжил зүйн техникийн болон боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зорилгоор Стандарт, хэмжил зүйн газартай хамтран ажиллах санамж бичгийг 2019.07.29-ний өдөр байгуулав.

5.3. Монгол Улсын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт ус хангамж, ариун цэврийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээг тогтвортой авч явах боловсон хүчнийг бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн бодлогыг бэхжүүлэх чиглэлээр Шинжлэх ухаан, Технологийн их сургуультай хамтран ажиллах санамж бичгийг 2019.07.05-ны өдөр байгуулав.



- 5.4. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчдыг чадваржуулах, мэргэжил арга зүйг сайжруулах асуудлаар гадаад, дотоодын сургалтыг зохион байгуулах, усны үнэ цэнэ, түүний зөв зохистой хэрэглээний талаар гарын авлага боловсруулах, олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор “Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо” ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийг 2019.07.01-ний өдөр байгуулав.
- 5.5. Зохицуулах зөвлөл болон Хот байгуулалт, нийтийн аж ахуйн ажилтны үйлдвэрчний эвлэлүүдийн холбоод хамтран “Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээр”-ийг Барилга, хот байгуулалтын ямаар батлуулав.
- 5.6. Зөвлөлийн дарга Ж.Батсуурь 2019.06.20-ны өдөр ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Уянгатай уулзаж, Усны аюулгүй байдлын талаар цаашид хамтран ажиллах санал солилцов.



5.7. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар, тус Зохицуулах зөвлөлөөс хамтран Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт-2030 хөтөлбөрийн зорилго 6.1, 6.2, 6.3.1-д тусгагдсан хүн амыг баталгаат ундны ус, сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангах, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахтай холбоотой стратегийн зорилтыг тодорхойлох Үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2019 оны 10 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулав.



5.8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор Төрийн ордны Их танхимд 2019.06.07-ны өдөр зохион байгуулагдсан “Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, цөлжилтийг бууруулахад тулгарч буй асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэгт Зохицуулах зөвлөлийн төлөөлөл оролцов.

5.9. Нийслэлийн захирагчийн ажлын албанаас 06 сарын 25-нд зохион байгуулсан “Хөрсний усанд автсан барилга, байгууламжийн судалгаа, дүгнэлтийн талаар танилцуулах уулзалт”-д Зохицуулах зөвлөлийн төлөөлөл оролцов.

5.10. Зохицуулах зөвлөлөөс 06 сарын 26-нд Нийслэлийн Байгаль орчны газрын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, Улаанбаатар хотын ундны усны чанар, аюулгүй байдлаар тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, зөрчил дутагдлыг арилгах талаар цаашид хамтран ажиллахаар болов.





5.11. Барилгын хөгжлийн төвтэй хамтран 2019.10.11-ний өдөр “Орон сууц, нийтийн аж ахуйн салбар үүсч, хөгжсөний 88 жилийн ойг тохиолдуулан удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг зохион байгуулав.



5.12. Зохицуулах зөвлөлөөс “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388” төслийн “Байгууллагын хөгжил ба чадавхийг сайжруулах” зөвлөх үйлчилгээний төслийн багтай хамтран 2019 оны 10 сарын 26, 27-ны өдрүүдэд Архангай, Өвөрхангай аймгуудад “Ус таны амьдралд” сэдэвт хэлэлцүүлгийг нийт 140 орчим иргэдийн дунд зохион байгуулав. Хэлэлцүүлгээр усны зүй зохистой хэрэглээ, үнэ цэнэ, усны үйлчилгээний тарифын өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэв.

5.13. Зохицуулах зөвлөлөөс 11 сарын 13-ны өдөр Нийслэлийн Сонгино-Хайрхан дүүргийн 76 дугаар дунд сургуулийн багш ажилчид болон 2020 онд төгсөх ангийн сурагчидтай уулзалт зохион байгуулж, ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа, салбарын чиг үүрэг, түүний онцлогийг танилцуулж, энэ салбарт ажиллах боломж, мэргэжлийн ач холбогдлын талаар ярилцлаа. Мөн тус сургуулийн багш, сурагчдын хэрэгцээнд зориулан 10 ширхэг компьютерыг “Багш хөгжлийн төв”-д хандивлав.





- 5.14. Монгол Улсын Засгийн газраас Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их хурлын даргад өргөн барьсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, тус Зохицуулах зөвлөлийн дарга нар 2019.12.12-ны өдөр хамтран Монгол Улсын Их хурлын дарга, УИХ дахь МАН-ын бүлгийн дарга, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга нарт зохицуулах байгууллагатай салбарын талаар санал, хүсэлтийг гаргав.
- 5.15. Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, Эрчим хүчний зохицуулах хорооны даргын 2019.09.17-ны өдрийн А/279, А/129 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан ЭХЗХ, УБХЗАА, ХСУХАТАҮЗЗ, ШӨХТГ, НМХГ, НӨАУГ, НЦУГ, НХБХГ, “УСУГ” ОНӨААТҮГ, “УБДС” ТӨХК, “ОСНААУГ” ОНӨААТҮГ байгууллагуудын холбогдох ажилтнуудаас бүрдсэн ажлын хэсэг нь нэр бүхий 9 компанийн үйл ажиллагааг газар дээр нь шалгаж холбогдох бичиг баримттай танилцаж санал дүгнэлтийг боловсруулан гаргасан.

### **Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр**

- 5.16. Дэлхийн усны чанарын холбооны Нэгдсэн Чуулганд 4-р сард АНУ-ын Лас-Вегас хотноо тус холбооны гишүүн, зөвлөлийн дарга Ж.Батсуурь оролцож, усны чанарын мэргэжилтэн бэлтгэх талаар хамтран ажиллахаар болов.





5.17. ХБНГУ-ын Франхоферийн институтийн усны секторын урилгаар Германы усны үйлчилгээний зохицуулалтын арга зүй, менежментийг судлах, сургалт судалгаанд 05-р сард зөвлөлийн төлөөлөгчид оролцов.



5.18. НҮБ-ийн Хүүхдийн сангаас 05 сарын 27-29-ний өдрүүдэд Тайландын Бангкок “Ус хангамж, ариун цэврийн байгууламж-Мэдлэгийн менежмент» олон улсын тэтгэлэгт сургалтанд албаны дарга Г.Нарантуяа оролцов.



5.19. Сингапурын засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангаас 08 сарын 17-23-нд зохион байгуулсан “Усны үйлчилгээний менежмент” сэдэвт тэтгэлэгт сургалтанд ахлах мэргэжилтэн С.Нямдаваа оролцож, Wash Bat судалгааны арга зүйд суралцав.





- 5.20. Итали Улсын Венец хотноо 09 сарын 07-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Олон улсын Усны холбооны “Усны нөөцийг зохистой хэрэглэх, нөхөн сэргээх үзэл баримтлалаас – практикт” олон улсын 3-р бага хуралд Зөвлөлийн дарга Ж.Батсуурь оролцов.
- 5.21. БНХАУ-ын Худалдааны Яамнаас Хөх хотноо 09 сард 1 сарын хугацаатай “Монгол Улсын бохир ус” сэдэвт сургалтад Зохицуулах зөвлөлийн мэргэжилтэн Ц.Оргил, Б.Билэгсайхан нар оролцов.



- 5.22. БНХАУ-ын Уухан хотод 09 сарын 23-25-нд Азийн Усны холбооны Удирдах зөвлөлийн 10 дугаар хурал (ВоС)-д Зохицуулалх зөвлөлийн төлөөлөгчид оролцов.
- 5.23. Усны олон улсын холбооны “Байгальд ээлтэй ус хангамж, ариутгах татуурга ба усыг эргүүлэн ашиглах чуулган”-д Зөвлөлийн төлөөлөл Улаанбаатар хотын “Ус сувгийн удирдах газар”-ын ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, хэлтсийн дарга Ж.Насантогтох нарыг оролцуулав.





- 5.24. Зохицуулах зөвлөлөөс Сингапур улсын PUB-тай хамтран тус улсад 11 сарын 23-28-ны өдрүүдэд “Сингапурын усны үйлчилгээний менежмент, үер борооны усыг хуримтлуулах татан зайлуулах талаар судлах сургалтыг зохион байгуулав. БХБЯ, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Зохицуулах зөвлөл, “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын төлөөлөл оролцов.
- 5.25. АХБ-аас 11 сард Филиппин Улсын Манила хотноо “Усны үйлчилгээний салбарын санхүүжилт” сэдэвт хэлэлцүүлэг, хуралд албаны дарга Ж.Гэрэлчулуун оролцов.



- 5.26. Шри-Ланк улсын Коломбо хотноо 11 сард Олон улсын Усны холбооны «Ус ба хөгжил олон улсын чуулга уулзалт 2019»-д албаны дарга Ж.Гэрэлчулуун УБ хотын усны “Aqua rating” үйлчилгээний салбарын үнэлгээ сэдэвт илтгэл тавьж оролцов.



## ЗУРГАА. Сургалт, зөвлөгөөний чиглэлээр

- 6.1. Туул голын сув газар, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Эм Си Эс Кока-Кола” ХХК дээр 2019.03.19-ний өдөр “Дахин ашиглах цэвэрлэсэн ус, техникийн ерөнхий шаардлага MNS-6734–2018” стандартыг сурталчлан таниулах сургалтыг ус ашиглагч томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудын хүрээнд зохион байгуулав.



- 6.2. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Нийслэлийн боловсролын газартай хамтран “Ус-тэгш хүртээмж” сэдэвт 40 минутын хичээлийн хөтөлбөрийг боловруулан нийслэлийн Ерөнхий боловсролын 112 сургуулийн бага, дунд, ахлах ангийн нийт 220000 гаруй сурагчдад мэргэжлийн инженер, техникийн 130 гаруй ажилтнууд танин мэдэхүйн хичээл заах ажлыг зохион байгуулав.



- 6.3. МНААҮХ-той хамтран «НАА-н салбарын нягтлан бодогчдыг чадавхжуулах сургалт»-ыг 2019.03.18-ны өдөр зохион байгуулав.
- 6.4. “Бохир ус зөөвөрлөх үйлчилгээ-2019” сургалтыг бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ үзүүлдэг 28 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 30 гаруй төлөөлөгчдөд зохион байгуулав.






- 6.5. “Булган мээж” ХХК, “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ, “Чандмань Баянхонгор” ХК, “Шим Ус” ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудын ус хангамжийн инженерүүдэд усны алдагдлыг бууруулах арга аргачлал, усны баланс тооцох “Water balance easy calculation” программ, ус хангамжийн гидравлик тооцоо хийдэг горим тооцооны “EPANET” программ, “Google Earth” программууд дээр ажиллах сургалт зохион байгуулав.



- 6.6. “Булган мээж” ХХК, “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ, “Чандмань Баянхонгор” ХК, “Шим Ус” ОНӨААТҮГ, “СУАТ” ХХК зэрэг байгууллагуудыг цахим хуудастай болгож, ашиглах, хөгжүүлэх талаар сургалт зохион байгуулав.



- 6.7. Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Дархан-Уул аймгийн ундны усны аюулгүй байдал” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулав. Сургалтанд ШУА, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн НЭМС, “Монголын Нийтийн аж ахуйн холбоо” ТББ-ын төлөөлөл оролцож сумдын Засаг дарга нар, ИТХ-ын Тэргүүлэгчдэд ундны усны аюулгүй байдлын талаар хичээл заав.





6.8. “ДорнодНАА” ОНӨААТҮГ, Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоотой хамтран 2019 оны 06 дугаар сарын 09-14-ий өдрүүдэд Дорнод аймгийн Чойбалсан хотод Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн, ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулав.





6.9. “Чандмань Баянхонгор” ХК-тай хамтран 2019.09.27-ны өдөр баруун аймгуудын нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудыг оролцуулсан “Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын удирдах ажилтны зөвлөлдөх уулзалт”-ыг зохион байгуулав.



6.10. Шинжлэх Ухааны Академитай хамтран “Уур амьсгалын өөрчлөлт-Усны менежмент” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2019.03.22-нд зохион байгуулав.



6.11. “Жайка” олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны талаар авах арга хэмжээний нөхцөл, байдлыг тодруулах судалгаа”-ны хүрээнд “Токио хотын ус сувгийн байгууллага, БХБЯ-аас зохион байгуулсан сургалт семинарт оролцон, санал солилцов.



## ДОЛОО. Судалгаа шинжилгээний чиглэлээр

7.1. ШУА-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд аймаг, орон нутгийн ундны усны чанарыг тодорхойлох, мэдээллийн санг бий болгох төслийн бичиг баримтыг боловсруулан, орон нутгаас сонгогдсон Улсын Их хурлын гишүүд, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад хүргүүлэн ажилласны үр дүнд Орхон, Дархан-Уул, Баянхонгор аймгууд болон нийслэлийн Хан-Уул дүүрэгт уг төслийг хэрэгжүүлсэн.



7.2. Монгол Улсын 21 аймаг, 330 сумын хариуцаж буй уурын зуух, гүний худгийн тоо, ус хангамж, ариутгах татуургын шугам, сүлжээ дэд бүтцийн судалгааг нэгтгэн, НААҮ-ний системд тулгамдаж буй асуудлаар танилцуулгыг бэлдэн, Монгол Улсын Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын дарга, тэргүүн дэд дарга нарт уламжлав.





- 7.3. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудыг чадавхижуулах сургалт, судалгааны төв байгуулах төслийг боловсруулж Азийн хөгжлийн банкинд хүргүүлэв.
- 7.4. Өмнийн говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах усны салбарын судалгааг боловсруулж МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнд хүргүүлэв.
- 7.5. Зохицуулах зөвлөлийн даргын баталсан 2019.06.24-ний өдрийн А/24 тоот тушаалын дагуу байгуулагдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандарт хэмжил зүйн газрын хамтарсан ажлын хэсэг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК-д газар дээр нь очиж ажиллан мэргэжлийн дүгнэлт, зөвлөмжийг гарган, Орон нутгийн Засаг даргатай хамтран “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийн одоо хуримтлагдаад байгаа 5.67 тэрбум төгрөгийн усны өр төлбөрийг шийдвэрлэн ажиллав.
- 7.6. Улаанбаатар хотын болон орон нутгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нарт ус хангамж, ариутгах татуургын өнөөгийн байдлын талаар танилцуулж, цаашид энэ чиглэлээр орон нутагт баримтлах бодлогыг тодорхойлон хүргэх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигч 30 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа мэдээллийг боловсруулав.
- 7.7. Зохицуулах зөвлөлөөс салбарын нягтлан бодох бүртгэлийн жишиг баримт бичгийг боловсруулах зөвлөх үйлчилгээг авч, тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын нягтлан бодогчдын дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа.

- 7.8. НАА-н байгууллагуудын ажилтнуудыг чадавхжуулах «МОН-3388» төслийн хүрээнд зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, НАА-н байгууллагуудын бүтцийн шижиг загварыг боловсруулж, БХБЯ-д хүргүүлэв.
- 7.9. “ЖАЙКА” олон улсын байгууллагын хүсэлтээр усны баланс, үйлдвэрийн газруудын бохир усны судалгааг гаргаж, Зохицуулах зөвлөлийн 2019.07.29-нд 02/719 тоотой хүргүүлэв.

## НАЙМ. Зохицуулах зөвлөлийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан



төгрөг

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ХУВЬ
<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,047,625,900.0</b>	<b>915,304,848.5</b>	<b>87.4</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	927,625,900.0	914,524,513.4	98.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	622,750.0	-
Хүүгийн орлого	-	157,585.1	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	120,000,000.0	-	-
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>1,047,625,900.0</b>	<b>1,015,822,075.4</b>	<b>96.5</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,831,500.0	527,133,754.7	95.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,099,800.0	65,848,649.3	99.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,060,000.0	54,060,000.0	100.0
Хангамж, бараа материалын зардал	28,331,200.0	27,904,666.9	98.5
Эд хогшил худалдан авах	5,536,000.0	5,535,500.0	100.0
Томилолт, зочны зардал	65,794,400.0	66,716,946.0	101.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	24,910,000.0	20,382,757.0	81.8
Бараа үйлчилгээний бусад зардал	78,630,000.0	78,588,316.0	99.9
Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,773,000.0	971,480.0	20.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,760,000.0	18,826,705.6	100.4
Тоног төхөөрөмж	149,900,000.0	149,853,300.0	100.0



## ЕС. Дүгнэлт

Тус Зохицуулах зөвлөл нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиар олгогдсон чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд 2019 онд нийт 101 ажил хийхээр төлөвлөснөөс 101 арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр гүйцэтгэж /гүйцэтгэл 98.3 хувь/ байна.

Үүнд дараах гол гол ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- ✓ Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор Усны Зохицуулах зөвлөл нь улсын байцаагчийн эрхтэй боллоо. Ингэсээнээр Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийг салбарт хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж хэрэглэгчийн эрхийг хамгаалах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, үйлчилгээ эрхлэгчдийг мэргэжлийн удирдлага, хяналтаар хангана. Мөн түүнчлэн Засгийн газрын 2019 оны 212 дугаар тогтоолоор Зохицуулах зөвлөлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт орлоо.
- ✓ Засгийн газрын 2019 оны “Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай” 474 дүгээр тогтоол батлагдснаар орон нутгийн түвшинд ус, дулаан хангамжийн үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд оруулах, төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах, усны үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдлыг арилгаж, ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй хүргэх зорилтыг биелүүлэх нөхцлийг бүрдүүлэв. Түүнчлэн орон даяар “Жорлонгийн хувьсгал”-г зарлан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ын зорилт 6.2-г хангуулах чиглэлээр олон ажлуудыг хэрэгжүүлж эхэллээ.
- ✓ Салбарын нягтлан бодох бүртгэлийн жишиг баримт бичигтэй болов. Нийтийн аж ахуйн салбарын ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зарчим, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох, хугацаат зээл тусламж, хөрөнгийн менежментийн зарчмыг салбарын онцлогт тохируулан, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.
- ✓ Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь сэдэвт үндэсний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан, Зохицуулах зөвлөл хамтран тус зөвлөлдөх уулзалтаар Тогтвортой хөгжлийн зорилт 6-д заасны дагуу ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг бүгдэд тэгш хүргэж, Хэнийг ч ардаа орхихгүй байх зарчмыг хэлэлцэж, зорилгод хүрэх шалгуур үзүүлэлт, дэлхий нийтийн арга аргачлалыг танилцуулж, зөвлөмж боловсруулав.
- ✓ “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр, төрлийн үзүүлэлтийн хүрээг” боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын А/175 тоот тушаалыг батлуулж, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн шалгуур үзүүлэлтүүдийн нэршлийг нэгдмэл болгосон байна.
- ✓ Нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд усны үйлчилгээний тарифын зохицуулалтыг цаг тухайд нь хийснээр валютын ханш, эрчим хүчний зардлын өсөлт зэргээс үүссэн санхүүгийн алдагдлыг 10 гаруй тэрбум төгрөгөөр бууруулж, салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах санхүү, эдийн засгийн нөхцөл бүрдлээ. 2019 онд шинээр 21 байгууллагад тусгай зөвшөөрөл олгож, 5-н тусгай зөвшөөрлийг цуцалж, 42 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгасан байна.
- ✓ Зохицуулах зөвлөлийн дэргэд Сургалт судалгааны төв байгуулагдлаа. Тус төв нь нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын боловсон хүчнийг чадавхижуулж, мэргэшүүлэх, улмаар АХБ-ны дэмжлэгтэйгээр ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр судалгаа, шинжилгээ явуулна.
- ✓ Ундны усны чанарыг тодорхойлох, технологийн шийдэл сонгох, мэдээллийн сан байгуулах иж бүрэн судалгааг эхлүүллээ. Усны чанарыг тодорхойлох, технологийн шийдэл сонгох, мэдээллийн сан байгуулах, иж бүрэн судалгааг ШУА-тай хамтран Орхон, Дархан-Уул, Баянхонгор аймгууд болон Нийслэлийн Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлэн улсын хэмжээнд усны чанарын мэдээллийн санг бүрдүүлж, усны аюулгүй байдлыг хангах, ундны усны чанарын талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй өгч эхэллээ.




















ХҮН

БАЙГАЛЬ

УС



**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

🏠 "Монгол Ньюс" тауэрын 6 давхар, 8-р хороо, Их тойруу 81/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

☎ (+976) 7014-7447  
🌐 <http://www.wsrc.gov.mn/>  
✉ [info@wsrc.mn](mailto:info@wsrc.mn)